



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/46

Мөрөн

Ажлын үр дүнг тооцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1. Аймгийн Засаг даргын 2012 оны А/166 дугаар захирамжаар батлагдсан “Хууль, эрх зүйн ажлын үзүүлэлтээр сумдын ажил дүгнэх журам”-д заасан шалгуур үзүүлэлт ёсоор сумдын 2014 оны ажлыг дүгнэхэд 92 хувиар үнэлэгдэж, нэгдүгээр байр эзэлсэн Түнэл сумыг аймгийн Засаг даргын шилжин явах цом, 200.000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Ажлын үзүүлэлтээр 60 хувиас доош дүгнэгдэж, хангалтгүй үнэлгээ авсан Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумдын Засаг дарга нар сумын Дотоод ажил, эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний ажиллах нөхцөл бололцоог ханган, техник хэрэгслийг шийдвэрлэн өгч, ажлын зохион байгуулалтыг зөв төлөвлөж, тодорхой арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

3. Түрүүлсэн сумын шагнал 200.000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнөгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/, Хууль зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР